

**МОНГОЛЫН УРАН ЗОХИОЛЫН ТУУЖ БИЧЛЭГТ ДҮРИЙН
СЭТГЭЛ ЗҮЙГ НЭЭСЭН НЬ**

(Д.Норовын “Хөх тавилан”, До.Цэнджавын “Хөх жавар” туужийн жишээгээр)

Б. Хишигсүх*

Монголын уран зохиолын хөгжлийн түүхэнд “тууж”-ийн төрөл зүйлийн хөгжил нэлээд эрт үеэс уламжлагдаж ирсэн билээ.

Бидэнд мэдэгдэж байгаагаар XIV зуунаас эхлээд “Чингисийн хоёр эр загалын тууж оршибай”, “Сулхарнайн тууж”, “Тэсэр”-ийн тууж, “Убаши хунтайжийн тууж”, “Хув Нагварал ба халхын Хатанбүүвэй баатрын тууж”, “Түр цагийн тууж”, “Бат хааны Рязанийг халдан довтолсон тухай тууж”, “Игорийн хорооны цэрэглэсэн тууж”, бурханы шашины сэдэвт, иргэний чиг хандлага бүхий “Багмай хатны тууж”, “Нарангэрэл дагинын тууж”, “Ногоон дарь эхийн тууж”, “Эндүүрэл хааны тууж”, “Молон тойн эхдээн ач хариулсны судар оршибай”, шинэ үеийн уран зохиолын хөгжлийн эхэн үед гэвэл Д.Нацагдоржийн “Хэлхээгүй сувд” (бүрэн бус), С.Буяннэмэхийн “Алсыг зорьсон алтан загас”, “Малчин Товуудай”, Ц.Дамбадоржийн “Толбо нуур”, М.Ядамсүрэнгийн “Залуу хос”, “Гурван хүүхэн” зэрэг туужуудыг нэрлэхэд хангалттай байна.

Тууж гэж юу вэ? туужид юуг, хэрхэн? яаж? дүрсэлж үзүүлэх, бичих талаар эрдэмтэн, судлаач Ши.Цэнд-Аюуш “Монгол тууж” ганц сэдэвт бүтээлдээ: “Туужид нийгмийн амьдралын аль нэгэн талыг тодорхойлон, хэсэг хүний үйл амьдралын тодорхой үйл явдал буюу гол баатрын амьдралын замнал хувиралт өөрчлөлтийг үзүүлсэн холбоо уялдаа бүхий хэд хэдэн үйл явдлыг нэгтгэн өгүүлдэг байна. Тодруулж хэлвэл, тууж гэдэг нь нийгмийн үзэгдэл байдал, хүмүүсийн үйл амьдралыг романд тусгаснаас бага, өгүүллэгт тусгаснаас их хэмжээгээр дүрслэн үзүүлдэг үргэлжилсэн үгийн зохиолын дундач төрөл зүйл юм.” (УБ.1981.7-8)¹ хэмээн тодорхойлсон байдаг.

Монголын уран зохиол дахь “тууж” бичлэгийн төрөл зүйлийг тусгайлан дагнаж судалсан судалгааны ажил цөөн байна.

Уран зохиолын “тууж” бичлэгийн төрлөөр ямар асуудлуудыг нээж үзүүлж болох талаар судлаач Ши.Цэнд-Аюуш: “...өнөөгийн шийдвэрлэгдээгүй асуудлуудыг өргөн хэмжээгээр авч үзэж, зөрчил учир шалтгааныг илэрхийлэн дүрслэх, хүмүүсийн ёс

* МУИС, Шинжлэх ухааны сургууль, Утга зохиолын тэнхим

¹) Ш.Цэнд-Аюуш, “Монгол тууж”, Улаанбаатар, 1981.

суртахууны мөн чанарыг хүмүүст нөлөөлөн байх нийгмийн орчин ахуй, ажил үүрэг, хүмүүсийн харилцаатай холбон уран сайхны дүрээр нээн үзүүлэх харьцангуй өргөн бололцоотой төрөл зүйл юм.” (УБ.1981.9)² гэжээ.

Монголын уран зохиолын тууж бичлэгийн төрөл зүйлийг авч үзвэл,

- Адал явдалт тууж
- Уран зөгнөлт тууж
- Цэрэг, эх орны сэдэвтэй тууж
- Хошин шог тууж
- Уянгын тууж
- Ёс суртахууны тууж
- Түүхэн сэдэвтэй тууж
- Сэтгэл зүйн тууж
- Баатарлаг явдлын тууж
- Баримтат тууж зэрэг болно.

Ёс суртахуун, сэтгэл зүйн туужийн хөгжилд С.Эрдэнийн “Цагаан дуганын гэгээ”, “Жаргах нас”, С.Удвалын “Ховор хүн”, Д.Мягмарын “Тээрэмчин”, “Үер”, Ж.Бямбын “Замбага ягаан цэцэг”, “Анхны хайрын дууль”, С.Дашдооровын “Урт намар”, Л.Чойжилсүрэнгийн “Шинийн гуравны саран”, “Амьдралын хавар” зэрэг туужуудад дүрийн сэтгэл зүйн асуудлыг нэлээд сонирхолтойгоор үзүүлсэн байдаг. Жишээлбэл, “Цагаан дуганын гэгээ” туужийн буриад басган Дэжидмаагийн цорж лам Бадрахад өгсөн хайр сэтгэл, хайрт хүнээ баривчлагдаад явах эцсийн мөчид сэтгэлийн асар их гуниг харуусал, дарамтаа үл даван үерлэсэн их голд үйж амиа егүүтгэж байгаа харамсалтай хувь тавилан, бэрх хэцүү зуднаар малдаа өгөх үмх өвс нь дуусаж, малаа барахын даваан дээр хайрт ижий нь хорвоогийн мөнх бусыг үзүүлж хүний амьдралын хатуу ширүүн бүхэн хайр найргүй нөмөрч ирсэн хүнд хэцүү өдрүүдэд Сүндэрьяа бүсгүй хань бараа болж байсан Самданг эр нөхрөө, гэсэн хүндлэл, сайхан сэтгэл нь баахан дур зоргоороо нэгэн болоход хүргэж улмаар жаргалдаа ташуурч толгой нь эргэсэн Самдан цаг бусаар хорвоогийн мөнх бусыг /согтуу хөлчүү давхиж, дөрөөндөө чирэгдэн насан эцэслэж байгаа/ үзүүлж байгаа харамсалт явдал, залуу сайхан бүсгүй Ундрам нутгийн залуучуудыг голж, өөрөөсөө насаар ахимаг нас дөч хүрч яваа, нуруу туруу сайхантай, цээж өргөн, нүд дүүрэн эр хүн хэмээн Тэгшээг хань нөхрөөрөө сонгож, эцэст нь хот газарт сургууль соёлын мөр хөөж явахдаа бага охиныг нь дэргэдээ авч өсгөн өндийлгөж харьж буцаж ирэхэд нь Тэгшээ аль хэдийнээ үе тэнгийн нэгэн ахимаг авгайг гэртээ авчирч цайны хүнээ болгосон байгаа амьдралын гашуун үнэнийг, эрх дураараа өссөн Нэргүй бүсгүйн амьдрал байдал эргээд өөрийнх нь сэтгэл доторхитой зөрчилдөн байгааг илэрхийлсэн “Тээрэмчин”, “Тээрэмчний охин”, тав тухтай, тохилог сайхан гэр оронтой, хариуцлагатай ажил албатай, түшиг нөмөртэй хэмээн сонгож, биширч, хүндэлсэн сэтгэлээр амьдралаа холбосон эр нөхөр болох Бадрахыгаа мэхэлж, үйлдвэрийн ажилчин залуу Галтад сэтгэл алдарч ухаан жолоогүй тэмүүлж байгаа Хорлоо бүсгүйн дүр зэрэг олон сонирхолтой дүрүүдийг амьдруулсан, бүтээсэн дээрхи туужууд 1950, 1960-аад оны Монголын уран зохиолын тууж бичлэгийн хөгжилд зохих хувь нэмрээ оруулсан билээ.

²⁾ Ш.Цэнд-Аюуш, “Монгол тууж”, Улаанбаатар, 1981.

Монголын нэн шинэхэн үеийн /1990 оноос хойшхи/ уран зохиол дахь “тууж”-ийн хөгжилд ёс суртахуун, дүрийн сэтгэл зүйн асуудлыг хурцаар хөндөж тавьсан тийм тууж харьцангуй цөөн гарч байна.

Бид энэ удаа зохиолч Д.Норовын “Хөх тавилан”, До.Цэнджавын “Хөх жавар” туужуудад дүрийн сэтгэл зүйг хэрхэн нээж, илэрхийлэн гаргаж тавьсныг ажигласан болно.

1982 онд Д.Норовын “Өнийн цэнхэр уулс” түүвэр хэвлэгдэж гарахад утга зохиолын судлаач, шүүмжлэгч Д.Галбаатар: “Манай утга зохиолын богино өгүүллэгийн төрөл зүйлийн залгамж тасалдаж мэдэхээр эгзэгтэй үед уянга-сэтгэл зүйн богино өгүүллэгүүдээрээ залган гарч ирсэн уран бүтээлч юм.” (УБ.2006.154)³ хэмээн үнэлсэн байдаг.

Тэрээр гагц өгүүллэгийн төрөлд уянга-сэтгэл зүйн шинжтэй бүтээлүүд туурвиад зогсоогүй тууж бичлэгт дүрийн сэтгэл зүйг хэрхэн нээж гаргаж, үзүүлж болохыг “Хөх тавилан” туужийнхаа өвөрмөц дүрээр харуулсан юм. Түүний туужийн баатруудын дүрийг ажиглахад дүрийг гаднах байдлаар нь тоочих, тодорхойлох уламжлалт аргыг төдийлөн хэрэглэхгүйгээр дүрийн сэтгэл хөдлөл, хувирлыг үйл явдлын өрнөлттэй холбож хурцаар илэрхийлж гаргасан нь, ээдрээтэй адал явдал, сүсэг бишрэл, туршуулын үйл, домог яриа, түүх, нийгмийн олон өгүүлэмжүүдийг сүлжилдүүлж, дүрийнхээ дотоод сэтгэл зүйг нээж харуулж байгаа нь ихээхэн сонирхолтой байгаа юм.

Зохиолч Д.Норов “Хөх тавилан” туужийнхаа “Бадамцэцэг ахайтан”-ы эх дүрийн талаар нэгэнтээ: “Говь-Алтай аймгийн Цогт сумын нутаг Ээж ууланд хаанаас ирсэн, хэн болох нь мэдэгдэхгүй Балжид гэх чавганц байсаар байгаад өнгөрсөн тэр бодит түүх миний тархины нэг үрчлээсэнд үлдчихэж. Хаана юу хийж явсан, аль нутгийн хүн юм бол доо, гээд үе үе түүнийгээ тэмтэрнэ. Хорь, гучин жил бодож явсаар байгаад нэг л мэдэхэд нөгөө чавганцынхаа дүрийг эндээс бүрдүүлж, “Хөх тавилан”-г бичсэн.” (УБ.2004.08.28.№202)⁴ хэмээн өгүүлсэн байдаг.

Үнэндээ бол “Хөх тавилан”-гийн Бадамцэцэг ахайтны дүр бол маш сонирхолтой дүр юм. Уг дүрийг нэн сонирхолтой болоход Монгол хүний сэтгэлийн тэнхээ, сэтгэлгээний онцлогийг нээж үзүүлэхдээ Бадамцэцэг “ахайтан”-ы сэтгэлийн хат, бэрх хэцүү амьдралын нугачаанд хэрхэн дасан зохицож, хүнд бүхнийг даван туулж хүний энэ насны амьдралд тохиолдож болох бүхий л гачланг үзэж, туулж байгаагийг нь үйл явдлаар сүлжилдүүлж, хурц зөрчил баялаг дүрслэл сонирхолтой зохиомжоор илэрхийлсэн байна.

Бадамцэцэгийн дүрийн сэтгэл зүйг нээж харуулахад ихээхэн нөлөөтэй, сонирхолтой бас нэг дүр бол “шарга морьт” хэмээх бодит ч юм шиг хийсвэр ч юм шиг дүр болно. Энэхүү “шарга морьт” бол нэг талаас харахад “хадны лам” баймаар нөгөө талаас харахад “гэгээнтэн” ч болмоор гурав дахь өнцгөөс харахад “хөөрхөн эмгэн” шөнө ямар нэгэн хий юмтай хэрэлдээд эсвэл хий юмтай ноцолдоод, яриад байгаагаагийг нь үзвэл “хий биет” ч гэмээр санагдаж байна.

Хорин жилийн хойно хотын сэтгүүлч, залуу хархүү олон жилийн хойно “хөөрхөн эмгэн”-ний гэрийн буурин дээр ирээд “- хэдэн жилийн хойно хүү чи нэг ирээрэй! Тэгэхэд бие минь арилсан, сүнс минь хоргодсон байх бий. Харин өдөр ирж, үзээд хий биетэн

³) Д.Галбаатар, “Урлахуйн галыг бадраагч, эндүүрлийн гэмийг арилгагч зул”, Улаанбаатар, 2006.

⁴) “Өнөөдөр сонин”. “Миний зохиолын баатрууд хувь тавилангаа өөрсдөө олдог”, Д.Норовын ярилцлага.

өндийх цагаас өмнө яваарай! Тэгэхгүй бол миний сүнс чамд шүглээд, чи хоёр сүнстэй болж, үйлээ үзнэ шүү гэж эмгэний хэлж байсан хахир хөх аялгуу чихнээ сонсогдох шиг болов.”/185/⁵ хэмээн санагалзаж байгаа нь сэтгэл сэрдхийм ямар нэг ёр совинг өгүүлж байгаа мэт. Бадамцэцэг ахайтныг бусдаас харамлаж суудаг тэр нэгэн “хий биет”-ийг туужид: “-Хүү чи хараа биз дээ? Манай гэрийн баруун хаяагаар... Яг чиний орон доогуур оготно нүхэлчихсэн байгааг... Наад муу зэтгэр чинь тэр нүхээр ороод ирлээ. Намайг харамлаж байгаа нь тэр. Одоо чамайг хорлох нь. Түргэн нааш ир! гэв..., -Боль чи! Зайл! Би ганц шөнө энэ хүүтэй жаргал зовлонгоо ярьж болдог юм байгаа биз дээ. Чи битгий гай болоод бай! гэх сацуу тохойноос үл үзэгдэх хүйтэн гар атган авч хэд хэд дугтрах нь тэр. Зүрхний гадуур үнхэлцэг байдаг даа, тэр хагарчих шиг боллоо.., ”/197/⁶ гэсэн “”хий биет эсвэл “буг, ороолон” ер аль нь ч гээд “хөөрхөн эмгэн”-ний дүрийг товойлгоход, дүрийн нь дотоод сэтгэлийг нээхэд нэг сэжүүр болж байгаа юм. Бас “хөөрхөн эмгэн”-ний дүрийг тодруулахад нөлөөлсөн дараагийн нэг сонирхолтой дүр бол тайжийн хүүгийн эхнэр болно. Учир нь Бадамцэцэг, тайжийн хүүтэй гэрлээд олон он болоход үр хүүхэд заяагаагүй бөгөөд тайжийн хүү тохиолдоор нутгийнхаа нэг хүүхэнтэй энгэр зөрүүлсэн нь хүүхэд олчихоод төрүүлсэн нь хүү аж. Ингээд цагаан яст тайж хүний удмыг бодож “ахайтан” төрхөмдөө буцсан нь хожим Бадамцэцэгийг хурдны морь унаад түрүүлж ирэхэд тайжийн хүү цулбуурдаж авч тогтоосон төдийгүй “... тайжийн эхнэр цай, хоол юу байгаагаа тэмтэрч нэрмэлийн охь, хүзүүндээ хадагтай хүрэн лонхноос маоту ч сөгнөж байна.., Тэгтэл тайжийн хүүгийн эхнэр намайг аргадаж:

-Миний дүү битгий уйл! Одоо яая гэхэв. Хүний заяа тавилан гэж ийм юм байдаг. Би сайндаа ч биш, хар нялхаасаа л цаадахыг чинь харж явсан болохоор нэг шөнө өвөр нээчихсэнээс ийм хэрэг болсон юм. Одоо яахав, чамд сайныг нь би мэднэ ээ. Гэхдээ үрдээ илүү сайн юм шиг байгаа юм. Чамайг хурдан морь унаж уралдаад ирэхэд би харж л байлаа. Үнэхээр өрөвдөж нулимс гаргасан шүү. Ашгүй муу хань минь бүр эр хүн шиг тосож очоод, угтаж авдаг байгаа даа. Миний баярласныг яана. Миний хань ч хүн шиг хүн юм даа гэж бодсон.., ”/203/⁷ гэснээс үзвэл тайжийн хүүгийн эхнэр гэгдэх төрсөн нь бүдүүн бааргадуу ч монгол хүний уужим сайхан сэтгэлийг тээсэн, монгол уламжлалаа дээдэлсэн холч ухаалаг эмэгтэй болох нь харагдаж байна. Уг туужид зөвхөн “хөөрхөн эмгэн, Бадамцэцэг ахайтан”-ы сэтгэлийн ертөнцийг төдийгүй түүний бэргэн эгч гэх гулгар улаан хүүхэн, тайжийн хүү, тайжийн хүүгийн эхнэр, говь зээрэн ноёны хадам ээж хэмээгдэх эмгэн /Бадамцэцэгийн хуурай ээж/, ахайтны олдмол хүү Оргодол, хадны лам, шарга морьт, хий биет нарын зэрэг хэд хэдэн дүрийн сэтгэл зүйн ертөнцийг сонирхолтойгоор нээж, үйл явдлын нарийн сүлжилдээн дунд тавьж үзүүлсэн нь тууж бичлэгт урд өмнө төдийлөн дүрслэгдээгүй хүний дотоод сэтгэлийн нууцлаг бүхнийг ил гаргаж зохих түвшинд нь хүртэл чадварлаг боловсруулсан явдал нь зохиолчийн ур чадвартай шууд холбоотой асуудал болно.

Зохиолч До.Цэнджавын “Хөх жавар” туужийн “харлаг” хэмээх нунж дорой Донойн дүрийн ертөнцийн хувирал, хувьсал, өөрчлөлт нь түүний эцэг “Хөх цавьт” хэмээх хочтой

⁵ “Хөх тавилан”, Улаанбаатар, 2003, 181-р тал.

⁶ “Хөх тавилан”, Улаанбаатар, 2003, 197-р тал.

⁷ “Хөх тавилан”, Улаанбаатар, 2003, 203-р тал.

дөрвөн үеэрээ хараалчийн удам “монди Тарав” хэмээгчийн үр сад “хар ховч” гэдэг овог судартай, хар хүчний муу зүгийн үйлийг хийж, насны эцэст түүнийхээ “үйлийн лай”-г эдэлж залуу хүүхэн дагаж одсон нүгэлт эр хүүдээ/Донойдоо/ хэл хүргүүлж, арайхийж уулзахдаа хар хүчнийхээ хараал жатгыг хийхдээ хэрэглэдэг “Бүсгүй хүний ширэлдсэн үс гээг, хүний өгөршсөн чөмөг, сүүжний яс, могойн хатаасан толгой, хөсгий тэвнэ, хэрээний савар, мэлхийний толгой, хагархай толь, боодолтой үнс, сангас., бүхий илгэн уутгай..”-г/21/⁸ өгч байна. Түүнийг гартаа оруулснаас хойш “харлаг” Доной ертөнцийг эзэгнэсэн мэт болж, аливаа муу муухай үйлээ хийх боломж бололцоо нь бүрдэж байгаа нь туужийн зангилаа болсон юм.

Энэ тухайд “Хөх жавар” туужид баяртай гунигтай, жаргалтай зовлонтой хүний амьдралын гэрэл гэгээ, эрээн бараан бүхнийг нэг шугаман дээр тавьж үзүүлсэн нь ихээхэн шинэлэг, сонирхолтой болсон ажээ. Тухайлбал: “... түүхий эдийн эрхлэгчид доромжлуулж, түмэн олонд ноцуулж, хулгана залгисан могой шиг цаашаа ч үгүй, наашаа ч үгүй болж, хэд хэдэн нэгдсэн тампуу шуудай ноосоо хүний байшин гуйж царайчлан байж хадгалуулаад толгой ганзгалан явж байх хооронд аав нь гол нь харласан цөгцний ёроол шиг ширгэсэн нүдтэй муу ээжийг нь хар нутаг дээр араг савартай нь хаячихаад хаашаа ч юм нүүгээд сураг тасарсан байв. Ханиа хаяж болно, гомдоож болно, зодож занчиж болно. Гэхдээ мөлхөөд ч зэлний дайтай явж чадахгүй таг сохор амьтныг халуун зунаар харангадуулж хаячихаад алга болно гэдэг бол Донойн хувьд хэзээ ч өршөөж болохгүй хатуу цээрлэл байлаа.” Дутуу алчихлаа аав чинь. Гүйцээчихсэн бол буян болох байсан юм.” гэж сэгсийж ойлгосон ээжийнх нь эхэр татсан дорой буурай дуу олон хоногийн турш түүний чихэнд хаджээ.” /16/⁹ гэсэн нь “... хоёр үе мултарсан залуухан хүүхэн дагаад тэндээ төвхнөснийг дуулаад гутахын дээдээр гутаж, жигшихийн дээдээр жигшиж, сэтгэл дотроосоо эцэг гэдэг хүнийг холоо гаргаж шидсэн байлаа. Уул тасарч унахгүй ч ураг тасарч гав руу орно. Чамайг ааваа гэвэл Хавиргын ус ширгэж, царцаа шувууны хоол болтугай. Уулзахын замд хад чулуу бутраг, улаан гол тасрахын цагт ч ухилахын нүгэл хураатугай...” /16/¹⁰ хэмээн ганц хүү Донойгоо өшрөөсөн эцэг нь болох “Хөх цавьт” хэмээх гурван үеэрээ хараалч жатгач явсан нэгэн бөгөөд тэрээр явуулын хүнээр “... амьдад минь ирж уулзаач, ярих маш чухал юм байна. үүнээс хождож болохгүй.” /14/¹¹ хэмээн дуудуулсанчлан, Доной эцгээ зорин очиж чухамдаа сүнс сүүдэр шиг болчихоод байсан аавтайгаа уулзаж, түүнээс хар хүчний шидийн учрыг олж мэдсэнээр урдын нунж дорой явсан, хүлцэнгүй ноомой гэх тэр “харлаг” Донойн эхийгээ өрөвдөж эцгийгээ үзэн ядсан сэтгэл нь нэгэнтээ эргэсэн нь ийм учиртай байна. Үүнд, Хүүр амилаад босоод ирвэл нэг ийм байх болов уу гэж санагдуулмаар, айж ширвээтмээр болсон “Хөх цавьт” хэмээх эцгийнх нь Доной хүүдээ хэлж байгаа сүүлчийн үгсдээ өгүүлсэнчлэн: “Энэхүү хараалч онгоны удам тасарвал дөчин дөрвөн хар тэнгэр, онгод сахиус манай удмаас хариугаа авдаг юм. Хар, цагаан хосолсон энэ орчлонг тэнцүүлэх юм заавал байх ёстой.., Дөчин дөрвөн хар тэнгэрийг өөрийн эрхшээлд захирна гэдэг хэн хүнд олдох шид биш. Хоньшигтой нь хонь шиг, чоношигтой

⁸⁾ “Хөх жавар”, Улаанбаатар, 2008, 21-р тал.

⁹⁾ “Хөх жавар”, Улаанбаатар, 2008, 16-р тал.

¹⁰⁾ “Хөх жавар”, Улаанбаатар, 2008, 16-р тал.

¹¹⁾ “Хөх жавар”, Улаанбаатар, 2008, 14-р тал.

нь чоно шиг л яв.” /22/¹² гэхтэй зэрэг Доной: “- Энэ тарни, номоор юу хүссэнээ ч хийж болох уу?, - Тэгэлгүй яахав. Бүх зүйл чинь нүдний чинь өмнө биелнэ. Би энэ муу залуу хүүхнийг тарни номынхоо хүчээр л өөртөө татсан юм шүү дээ. Хүсэл тачаалаа ч гүйцээж болно.” /23/¹³ гэсэн эцгийнхээ үгийг сонсож суухдаа тэрээр: “... Юу хүссэнээ хийж болно гэнээ” гэж дотроо үглэн, саяхан л үүлгэртээд учраа олохгүй, мэгдэж байсан Доной алгуур аажмаар ер бусын зоригоор хөвчлөгдөв.” /24/¹⁴ гэсэн нь зохиолын нэгэн зангилаа асуудал болж байгаа төдийгүй ёстой нөгөө “муу хүнд үг бүү дуулга, мухар үхэрт худаг бүүүзүүл” гэгчийн үлгэр ингэж эхэлсэн болно.

Чухамдаа эндээс л харлаг Донойн урдын сул дорой байдал, ам хэлээ үдүүлчихсэн юм шиг дуугарах ч үгүй, хүн хүний өмнө гөлөн гөлөн хийж, ус балгачихсан юм шиг байдаг тийм зан төрх эрс өөрчлөгдөж юуны түрүүнд “” үзвэл мөн ч гоё байх даа” гэж дотроо хүсч тачаадаж явдаг жаахан Бадамаагийн жоготой хар нүд тормолзон, цог жавхлан нүүрнийхээ арьсны цаанаас нэвт туяарч гэрэлтсэн зүс царай бүүр холоос тодроод ирэх шиг болоход...” /24/¹⁵ улмаар “Бас нөгөө заналт түүхий эдийн эрхлэгчийн нуруугаа үүрээд, байшингаа түгжчихээд маадгар алхаж байгаа дүр төрх орж ирэв.” /24/¹⁶ гэх зэргээр өөрийн нүгэлт үйлийг үйлдэх гэсэн, байж ядсан хорон муу үйл бүхнээ хийж бузар санаагаа гүйцэлдүүлэх гэсэн атгаг сэтгэлийн хорт могой дотроос нь хатгаж байгаа нь зохиолын хурц зөрчилийн эрчийг түргэсгэж буй хэрэг явдал болдог.

“Хөх жавар” туужийн харлаг Донойн дүрээр хувь хүний зан чанар, хийж буй хорон муу үйл бүхнийг нэгэн зэрэг нэг шугаман дээр тавьж үзүүлсэн нь тууж бичлэгийн төрөлд анх удаа “харшлалт дүр”-ийг бүтээхэд ихээхэн бүтээлч ач холбогдолтой болсон төдийгүй өнөөдрийг хүртэл бүтээгдэж ирсэн тууж зохиолын дүрийг өөр өнцгөөс харахад судлаачдад боломж олгож байгаагаараа уран зохиол дахь дүрийн судлалд маш сонирхолтой асуудлыг дэвшүүлж тавьсан байна. “Харлаг” Доной нэгэн удаа баян Намжил (Бадамаагийн нөхөр)-ын унагаа тамгалах найран дээр нь орж таарч, эхний айраг Донойд хүрэлгүй алгассан нь тун санамсаргүй хэрэг байсан бөгөөд үүнийг Намжил ч мэдээгүй, найрын сөнч ч анзаараагүй атал Доной өс бодон мэс шиг сэтгэл өвөрлөж: “-Жа, Намжилаа гялайлаа, маргааш би суудлаа гарахлаар танай энэ том хулаар уунаа, одоо мордьё доо гээд унь сугарч унатал хаалга саваад гарахад хүмүүс юу болоов, өдий насалчихаад тоглоом даадаггүй барам уу даа, харлаг Доной хаа холддог юм, том хар морио мэндүү гэдгийг харчихаад эргэж сууна биз, ай болохгүй цаадахаа гомдоож болохгүй, хар хэлтэй аягүй муухай хүн шүү, буянд чинь бузар орно гэж ам амандаа шагшилдана.” /42/¹⁷ гэсний орой нар жаргахаас өмнө Намжил гэнэтхэн л цусаар бөөлжсөөр амь тавьж байгаа нь чухамдаа харлаг Донойн өөрийнхөө чивэлт хүслийг гүйцээхийн тулд хөөрхөн Бадамаад тачаадан шунаж явдгийнхаа улмаас эцсийг нь үзэх гэсэн аазгай нь хөдөлж гэрийн эзнийг үхэлд хүргэж байгаа нь уг дүрийн мөн чанарыг тодруулж байна. Цааш нь нутаг усныхныхаа итгэл хүндэтгэлийг хүлээсэн сайхан сэтгэлтэй, тусч элэгсэг Ишдоржийг харааж, амьдаар

¹²⁾ “Хөх жавар”, Улаанбаатар, 2008, 22-р тал.

¹³⁾ “Хөх жавар”, Улаанбаатар, 2008, 23-р тал.

¹⁴⁾ “Хөх жавар”, Улаанбаатар, 2008, 24-р тал.

¹⁵⁾ “Хөх жавар”, Улаанбаатар, 2008, 24-р тал.

¹⁶⁾ “Хөх жавар”, Улаанбаатар, 2008, 24-р тал.

¹⁷⁾ “Хөх жавар”, Улаанбаатар, 2008, 42-р тал.

нь өт батгана шавуулсан яр шархны халуунд тарчилгаж, өсгөсөн ганц охин Дунгаамаагийнхаа хайртай хань Хүрэлээг цэл залуугаар нь элгээр нь бөөлжүүлэн хорвоогоос ангижруулж, ханилсан хань Хажидыгаа сэтгэлийн тэвчишгүй хүнд дарамтанд оруулж амиа егүүтгэхэд хүргэж байгаа зэрэг нь харлаг Донойн араатан авир шинж дээд цэгтээ хүрч байгаагийн аймшигт илрэлүүд болж байна. Харлаг Доной энэ бүхэндээ эрэмшиж: “- Бадамаа, чи намайг эгцэлж хараач. Би цагаандаа гарсан хүн шүү. Араанд минь муусайн том жижиг амьтдын элэг амтагдаад байдаг болчихлоо. Намайг жирийн нэг ядарсан хүн биш, харын тэнгэрийн элч юм байна гэдгийг үүгээр түүгээр овоо гадарладаг болоо биз. Би зүгээр нэг тагш саам, хэдэн халтар төгрөгнөөс болоод чиний Намжилыг чинь цааш нь харуулаагүй. Намайг гутааж доромжилж, нэр төрийг минь дэвсэлсний төлөөснөө хар тэнгэрийн зараалаар зохих хариугаа авсан юм.” /44/¹⁸ гэж хоёр өнчин хүүхэдтэйгээ цэл залуугаараа бэлэвсрэн хоцорч, талийгаачийнхаа хойдохын 49 хоногийн эмгэнэлийн ёсыг ч үйлдээгүй байгаа хатуу хорвоогийн хүнд хэцүүөдрүүдэд үймэрч туймарч суугаа, хүч чадалгүй сул дорой бүсгүй (Бадамаа) хүнийг амьдаар нь сэтгэлийн тамд унагаж байгаа нь уг туужийн эмгэнэлтэй асуудлуудын нэг бөгөөд Донойн дүрийн дотоод ертөнцийн түнэр харанхуйд өчүүхэн ч атугай гэрэл гэгээ үгүй болохыг харуулж байна.

“Хөх жавар” тууж зохиолын хэл, найруулгын хувьд энгийн мэт боловч уламжлалт монгол сэтгэлгээтэй нягт уялдуулсан, цар хүрээний хувьд үлэмж баян, аливааг өгүүлэхдээ нүдэнд үзэгдэж сэтгэлд буутал тод томруун дүрслэн илэрхийлж чадсан нь зохиолчийн туурвил зүйн өвөрмөц арга барилтай уран бүтээлч болохыг нь бэлхнээ илтгэж байна.

1980-ад оны сүүлч, 1990-эд оны дунд үеийг хүртэл Доржзовдын Энхболдын “Шар хөвийн дөрөлж”, Пүрэвжавын Баярсайхны “Шар нохойн хэвтэш” зэрэг гарын таван хуруунд ч хүрэхээргүй ганц нэгхэн чамбай бүтээл төрж уншигч, судлаачдын оюуны цангааг тайлж байсныг эс тооцвол үнэндээ шинэ үеийн Монголын уран зохиолын хүүрнэсэн зохиолын ялангуяа тууж бичлэг нэгэн хэвийн уйтгартай, хэл найруулгын хувьд хөшингө, баригдмал байсан гээд хэлчихвэл хатуудсан болчихгүй болов уу.

Тэгвэл дээр дурдсан “Хөх тавилан”, “Хөх жавар” туужууд цагийн салхийг сөрөн гарч ирж, нэн шинэхэн үеийн монгол уран зохиолын хөгжилд ялангуяа тууж бичлэгт нэгэн хүчит түрлэг болон орж ирснийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Зохиолч Д.Норов, До.Цэнджав нарын зарим өгүүллэг, туужийг уншиж суухад нээрээ үнэхээр ийм хэцүү цөвүүн цаг үед бид аж төрж байгаа юмсан бил үү, хэмээн өөрөө өөрөөсөө асууж өөрийн эрхгүй хүмүүний амьдралын гашуун үнэнийг эргэцүүлэн бодоход хүргэж байна.

Энэ бол зохиолчийн сэтгэлгээний цар хүрээний чадамж өргөн, үгээр урлахын уран чадвар нь нэгэнт эрийн цээнд хүрснийг харуулж байгаа хэрэг бөгөөд энэ ч утгаараа Д.Норов, До.Цэнджав нар нэн шинэхэн үеийн монгол уран зохиолын тэн тэнгийн ачаанаас цаашдаа ч үүрэлцэх нь тэдний хүмүүний энэ төрөлд нь ноогдсон хувь тавилан буй за.

Мухар сүсэг гэхээсээ илүүтэйгээр бодтой ч байж болохоор нэг асуудал бол өдгөө ч яригдаж, хэлэгдэж л байдаг “хараал, жатга”-ын тухай асуудал юм. Хүн төрөлхтөний хөгжил дээд цэгтээ хүрсэн энэхүү эрин үед аж төрж байгаа хэмээн яригдаж, бичигдэх

¹⁸⁾ “Хөх жавар”, Улаанбаатар, 2008, 44-р тал.

болсон өнөөгийн цаг үед бас ийм зүйл байна гэж үү, хэмээн эргэлзэн тээнгэлзэх нэгэн ч байх юм.

Дээр дурдсан туужийн зангилаа асуудал хэрхэн тайлагдах нь ихээхэн ээдрээтэй бөгөөд тайлал нь маш хурц, нэн эмгэнэлтэй гунигтай байдлаар шийдэлд хүргэхэд хүрч байгаа нь зохиолд өгүүлсэнчилэн “харлаг Доной”-н голомтон дээр өсөж өндийсэн цэцэг цэврүү шиг сайхан, хүний ганц охин Дунгаамаагийн амьдралын эмгэнэлт хувь заяаны гашуудалт төгсгөл бэлхнээ харуулж байна. Ээж, аавын эрх танхи өссөн ганц охин тэрбээр нутгийн зон олондоо тусч сайхан сэтгэлээрээ хүндлэгдэн хайрлагдсан Ишдоржийн ууган охин болж төрсөн боловч гунигт амьдралын хатуу тавилангаар “харлаг” хэмээх Донойн гэрт өсөж өндийн арван найман нас хүрсэн нь чухамдаа хүмүүний амьдралын үйлийн үр гэдэг энэ л болов уу, гэлтэй санагдана. Ядаж байхад энэ айлын хоттой хонь нь хүртэл дан харлаг зүсмийн байгаа нь үнэн хэрэг дээрээ бол гагц Доной хэмээхийн дүр, байдал төрхийг илэрхийлж байгаа сонирхолтой нэгэн дүр зураг байна. Хажидын ганц охины эмгэнэлт хувь тавилан цэл залуу ид урган цэцэглэх сайхан насан дээрээ “эцэг” Донойн хараалаар хайрт залуу Хүрлээгээ цаг бусаар алдаж, энэрэлт сайхан ижий нь хорвоогийн хамгийн муухай үхэл болох “өөрөө өөрийгөө боомилох” амиан егүүтгэх аймшигт харуусалт үхлээр ганц охиноосоон хагацаж, эцэст нь Дунгаамаа бүсгүй сайхан зүс, гоо царайгаа үзэшгүй муухайгаар эрэмдэглэж (нүүр лүүгээ хүчил цацан түлж зэрэмдэглэсэн) “хүн чөтгөр” болж байгаа нь бүсгүйн өөрийнх нь бодлоор бол “Намайг хараад хүмүүс айг, цочиг... Тэр тоолонд эрлэг Донойг үзэн ядна. Ийм бузрын муухай юм энэ амьдралд байдаг байна шүү гэдгийг мэднэ, ухаарна... Ийм хараал гэгч юм байдаг юм байна гэдгийг дарга нар ухаараг. /95/¹⁹ хэмээн өрөвдөлтэйгээр өр зүсэм цурхиран уйлаад гаслан өгүүлж байгаа нь уг туужийн гүн эмгэнэлт шийдэл болсон байна. Аяа, ухаант хүмүүний ертөнц гэдэг ийм аймшигийг өөртөө агуулж байгаа юм, гэж үү хэмээн харуусан халагламаар.

“Хөх жавар” туужийн бас нэгэн баатар болох Ишдоржийн дүрийн шугамыг зохиолч ихээхэн ээдрээтэй байдлаар үзүүлсэн нь сонирхолтой болсон юм. Учир нь Хажид, Ишдорж хоёрын ханилж амьдраагүй хатуу хувь тавилангийн дундаас төрсөн Дунгаамаа охины амьдралын хамгийн эмгэнэлт гашуун, хатуу хөтүү дунд төрсөн эцэг Ишдорж нь байж, харлаг Донойн хараалаар нэгэн хэсэг тарчилж байсан бөгөөд Хажидын сайхан сэтгэлийн үрээр үйл лайт /халуун зунаар идээ бээр нь цувж, түүн дээр нь ялаа батгана шавсан аймшигт дүр зураг/ өвчнөөсөө ангижирч улмаар нутгийн зон олноо цаашдын аймшигт хар хэргүүдийн золиос болохыг үзэж харж, сонсож тэвчихгүй, ганц охин Дунгаамаагийнх нь эмгэнэлт хувь тавилангийн төгсгөл зэрэг нь түүнийг ийн үйлдүүлэхэд хүргэж: “Ишдорж нэг мэдэхэд л Донойн гэрийн гадаа ирээд морио хантайртал татаад үсрэн буув. Тэрээр Донойг орноосоо өндийхийн хооронд,

-Муу хар мангас, олон гэмгүй хүний цусыг сорж ханв уу? гээд улаан нүүрэн дундуур том гараараа байдаг чадлаараа дэлсэв. Доной нүүрээ дарж унахад хамраар нь олгойдсон цусыг гарынхаа алган дээр тосоод аваад Донойн ам руу хүчээр цутгав. Хараал хийжээ гэдгийг мэдвэл нөгөө хүний хамраас нь цус гаргаад аманд нь хийх домтой юм шүү дээ гэж Ишдорж Дамбий ламын амнаас сонсжээ. Чи ингээд ах дүү амраг саднаа алаад бай. Алаад бай. Хар яргачин... газар дэлхий дээр багтаж шингэхгүй амьтан... гээд дахин дахин дэлсэв.

¹⁹⁾ “Хөх жавар”, Улаанбаатар, 2008, 95-р тал.

Нүүр ам нь үрчийж, сүнсгүй болсон Доной мөчигөөгөлгүй Ишдорж руу нулимж, “Чамайг өрөвдөөд дутуу үлдээсэндээ харамсаж байна. Одоо гүйцээнэ дээ” гээд ухасхийхэд түүнийг тэр дороо өвдөглөн “Би чамайг алж гараа бузарлахгүй. Чамайг олон сайхан амьтдын өмнөөс цээрлүүлнэ. Ётой тэнгэр бурхан хардаг юм бол харах биз гээд түүнийг янгинатал хүлэв. Хараал хар толгой дээр чинь тусна гэдэг энэ. Чи одоо хулганын ч чадалгүй болсон. Чиний амийг нэхэх хүн байхгүй. Чамайг үхэхэд олон амьтан, нутаг усныхан тэр чигээрээ баярлана. Амаржина. Чи бол ёстой босоо ороолон болжээ. Би босоо ороолонг дарж буян хийж байгаа юм” гэж хэлээд гэрт нь гал тавив. Хаврын хөх салхи галыг нүд ирмэхийн зуур хөөргөдөж их гал дүрэлзэн юу ч үгүй хуйхалжээ.” /96/²⁰ хэмээн харлаг Донойн хувь тавилангийн төгсгөл гарцаагүй гашуун эмгэнэлтэйгээр шийдэгдэж байгаа нь “нүгэл нүдээрээ гардаг” гэх буюу эсвэл “хараал хар толгойдоо” гэдгийн үлгэрээр болж байна. “Муугийн явдал олонд, могойн цус тэнгэрт” гэгчээр сайхан сэтгэлт Ишдорж нутгийн харалган эрх мэдэлтнүүд хийгээд байцаагч залуухан дэслэгч тэргүүтний эрхшээлээр ялгүй ялтан, хэрэг үйлдээгүй хэрэгтэн болж байгаа нь уг туужийн эмгэнэлийн эмгэнэл болжээ.

Цөвүүн цагийн дүр зургийг, хүмүүний гачлант ертөнцийн өнгө төрхийг зохиолч ийн өгүүлж: “Мянган жилд ч үл тохиох ямар гачлантай, ямар муухай, ямар энэрэлгүй муухай агшин гэгч энэ вэ? Бүгд л хөмөрсөн тогоонд байгаа шиг, бөөн үхдлийн дунд, хав харанхуйд зогсоо шиг...” /98/²¹ хэмээжээ. Харлаг Донойн хувьд “нохойн үхэл”-ээр хорвоог орхиж нэгэнтээ нутгийн зон олны сэтгэл айдас хүйдсээс ангижирч, тийм аймшигт нүгэлтнийг дааж байсан хүмүүний орчлон амсхийх нь зохиолчийн хүсэл мөрөөдлөөс үүдсэн бус ерөөсөө Донойн дүрийн хувь тавилан нь тэр юмаа.

“Хөх жавар” туужийн “Хөх цавьт”, “Харлаг” Доной, Дунгаамаа нарын дүрийг давтагдашгүй өвөрмөцөөр урлан бүтээсэн дүрийн шинэчлэлээр, ийм өвөрмөц дүрүүдийг илүү дутуу гоёж чимэлгүй, хуурай хоосон үгээр чамирхалгүй, энгийн монгол өгүүлэмж, хүүрнэлээр гэсэн хэрнээ нүдэнд харагдаж, гарт баригдтал зураглаж дүрсэлсэн дүрслэлийн онцлогоор, үйл явдлуудын хойно хойноосоо хөврөх эргэлт, хурц шийдлүүдээр тайлбарлагдана.

Зохиогчийн дуун алдсанчлан “Ямар үйлийн үртэй хорвоо. Үнэнээр явсан нь ингэж үйрч дуусах ёстой юм гэж үү? Хүн яагаад адгуус шиг байдаг юм бэ? Хүн ёсоор амьдарч болохгүй юм гэж үү? Хүн хүнээ хэзээ хайрлах юм бэ?..” /104/²² хэмээсэн нь хувьсан өөрчлөгдөх цагийн өнгө болов уу?

Уран зохиолыг дан нэг талыг барьж, нэг л шугамаар бичиж ирсэн тэр арга барил, нөхцөл байдлаас ангижирч чадсан нь дээрхи туужуудийн үнэ цэнийг тодорхойлох бөгөөд “Хөх тавилан”, “Хөх жавар” туужууд нэн шинэхэн үеийн монгол уран зохиолын тууж бичлэгийн төрөл зүйлийн хөгжилд шинэчлэл хийсэн бүтээлүүд болж чадсан юм.

²⁰ “Хөх жавар”, Улаанбаатар, 2008, 96-р тал.

²¹ “Хөх жавар”, Улаанбаатар, 2008, 98-р тал.

²² “Хөх жавар”, Улаанбаатар, 2008, 104-р тал.

НОМ ЗҮЙ

1. Баярсайхан Б. (1994), “Шар нохойн хэвтэш”, Улаанбаатар.
2. Белинский В.Г. (1990), “Урлаг уран зохиолын тухай” Улаанбаатар.
3. Гаадамба М. “Зохиолчийн хөдөлмөр”
4. Гаадамба Ш. (1989), “Утга зохиолын онолын үндэс”, Улаанбаатар.
5. Гаадамба М. (1958), “Утга зохиолын онолын товч”, Улаанбаатар.
6. Галбаатар Д. (2002), “Уран зохиолын онолын ойлголт, нэр томъёоны тайлбар толь”, Токио.
7. Галбаатар Д. (2003), Peculiarities of D.Norov’s narrative ‘Khukh Tavilan’. Улаанбаатар.
8. Гегель Г.В. (1968), “Эстетика” I, II Москва.
9. Гэрэлт Б. (1989), “Утга зохиолын онолын хураангуй”, Хөх хот.
10. Дамбадорж Ц. (1924), “Толбо нуур”, Улаанбаатар.
11. Жамсранжав Г. (1974), “Эрлийн цаана эрэл”, Улаанбаатар.
12. НоровД. (2003), “Хөх тавилан”, Улаанбаатар.
13. Уэллек Р., Уоррен О. (1998), “Уран зохиолын онол”, Улаанбаатар.
14. Софокл (1958), “Трагедий”, Москва.
15. Туяасайхан Ч. (2000), “Уран зохиол сэтгэл зүйн судалгааны зарим асуудал”, Улаанбаатар.
16. Цейтлин А. (1968.), “Труд писателя”, Москва.
17. Цэдэв Д. (1978), “Зохиолчийн урлах эрдэм”, Улаанбаатар.
18. Цэнд-Аюуш Ши. (1981), “Монгол тууж”, Улаанбаатар.
19. Цэнджав До. (2008), “Хөх жавар”, Улаанбаатар.
20. Чернышевский Н.Г. (1980), “Урлаг үнэн байдалтай гоо зүйн талаар харьцах учир”, Улаанбаатар.
21. Энхбаяр С. (2000), “Утга зохиолын онолын туурвил зүй”, Улаанбаатар.
22. Энхболд Д. (1991), “Шар Хөвийн дөрөлж”, Улаанбаатар.
23. Эсхил (1989), “Трагедий”, Москва.

SUMMARY

The characters ‘*Khukh tsavit*’, ‘*Kharlag*’Donoi and Dungaamaa of a novel “*Khukh javar*” are described fantastically through the sequences of plots, even though they are to be explained by the new descriptive style of characters which uses Mongolian common narratives without any epithet.

In this paper, the author discusses the values of the creations “*Khukh tavilan*” and “*Khukh javar*” are that they could get rid of conventional methods and they could become the works which renovated the development of the novel genre in the modern Mongolian literature.